МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

2018.12.31 № 1523

танай ______ -ны № ______ -т

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Г.БИЛГҮҮН ТАНАА

Төрийн жинхэнэ албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэй Бат-Эрдэнийн Энхбат, Даалхайн Батболд, Оюунбаатарын Оюунзул, Очирын Амарбат нарыг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоонуудад нэр дэвшүүлэн томилох тухай саналыг холбогдох баримт бичгүүдийн хамт 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 28 тоот албан бичгүүдээр Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг зохих журмын дагуу хянан үзлээ.

Дээрх иргэд нь тус тусын ажлын байрны тодорхойлолтод тавигдсан ерөнхий шаардлагыг хангаж байх тул Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам"-ын "Зургаа"-ийн 6.2.3-т заасныг тус тус үндэслэн,

1.Бат-Эрдэнийн Энхбатыг Төрийн захиргааны удирдлагын газрын хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтний,

2.Даалхайн Батболдыг Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтний;

3.Оюунбаатарын Оюунзулыг Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтний,

4.Очирын Амарбатыг Оюуны өмчийн газрын Захиргаа удирдлагын хэлтсийн эрх зүй хүний нөөц хариуцсан мэргэжилтний албан тушаалд тус тус томилуулахаар Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлж, мэргэшлийн шалгалтын материалыг хүргүүлж байна.

"Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан шаардлага, нэр дэвшигчийн их, дээд сургууль төгссөн дипломын хүчинтэй эсэх, эрүүл мэндийн байдлын талаар нь магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын дүгнэлт, улс төрийн намын гишүүн бол Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу намын гишүүнчлэлээс түдгэлзсэн тухай баримт бичиг зэргийг холбогдох байгууллагуудаас нь албан ёсоор авч нэр дэвшигчдийг томилсон шийдвэрийг ирүүлнэ үү.

Хавсралт хуудас

ДАРГА Б.ЦОГОО